Ярилцлага өгөгчийн нэр	Чимэддовдон	Дугаар	L343
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Баянжаргалан
Төрсөн газар	Баянжаргалан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан суух байсан сүм хийд	Уулын мамбын хийд	Сүм хийдийн дугаар	ДУГС 055
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Жужа, Энхбаяр

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Уулын мамбын хийд

Жужа: За одоо яриагаа эхлэе. Энэ ажиллаж байна, дуу хураааж эхэлсэн.

Энхбаяр: Баянжаргалан сумын нутаг дэвсгэр дээр эртний ямар хурал хийдийн газар байсан бэ?

Чимэддовдон: Тэр Их газрын чулууны урд талд Уулын мамба гэж хийд байсан. тэр чинь манай хийд байсан юм.

Энхбаяр: Аан, бид нар очсон. Их газрын чулууны баруун урд гурван дуганы түүрь байна лээ.

Чимэддовдон: Өө за тэр чинь , тэр чинь мөн дөө. Урдаа нэг дуган, хойноо зэрэгцээ хоёр дуганы түүрь байх ёстой.

Энхбаяр: Нэг маарамба лам хэдэн шавьтайгаа сууж байсан гэж нутгийн нэг хүн ярьж байсан?

Чимэддовдон: За за тийм байх. Тэр ч их шажин хаагдахын дөнгөж өмнөх үе болов уу.

Энхбаяр: Тэр баруунтаа нэг суварганы түүрь байсан уу?

Чимэддовдон: Аа мэдэхгүй. Суварга байсан байлгүй дээ.

Энхбаяр: Энэ танай шинэ хийд хэдэн онд байгуулагдсан бэ?

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Чимэддовдон: 1992 онд байгуулагдсан.

Энхбаяр: Тэр үед настай өвгөн лам нар олон байв уу?

Чимэддовдон. Арваад өвгөн лам нар байсан.

Энхбаяр: Анхны хамба лам нь ямар хүн байв?

Чимэддовдон: За энэ түүхийг яривал бас их сонин. Манай хийдийн анхны ерөөлийг Зүүн чойроос лам нар ирж хурж байсан юм байна. Тиймээс эхэндээ Зүүн чойрын харъяа гэж манай хийд хурал явж байж. Энэ үед Зүүн Чойрын их гэвш Дамбил гэж лам , гэсгүй Содов лам нар ахалж байсан юм. За Зүүн Чойроос арваад настай өвгөд лам нар , манайхаас арваад өвгөд багачуул нийлээд нэг хориод лам хувраг цуглаж хурал эхэлсэн. Ингээд дараа нь одоо энэ Дэлгэрцогтын өвгөн, өө нэр нь алга боллоо хэн билээ, бид Шар өвгөн гэдэг байсан юм. Гэлэн хүн, их настай хүн тэр хүн тэргүлж байсан юм. Тэгээд өвгөн 4-5 жилийн өмнө хот руу шилжээд явсан. Тэгээд би л одоо хийдээ хариуцах болсон. Ер нь одоо энэ манай хийдэд Лодой, Агваандорж, Самбуу , Зундуй , Лувсандорж, Норовренчин, Доржжамц гээд арваад өвгөн байсан юм. Одоо цөөрсөн дөө. Тэгээд одоо би нэг өвгөнтэйгөө л үлдэж дээ. Лодой маань Чойрт, Агваандорж маань Дэлгэрцогтод , нэг өвгөн маань хэвтэрт орсон. Яахав миний гараар орж айлд нэг сан үншихчаан болсон гурван бандитай, нэг нь хойшоо хот руу Шашны дүнд сургуульд явсан. Бас нэг номтой, номгүй жижиг гурав дөрвөн юм бий. Тийм л юм даа. За тэгээд би нэг иймэрхүү долоон найман бандитай л аун. Цуглахаараа нэг долоо наймуулаа цугладаг юм. Уг нь тэр би Зүүн Чойрт хурал тогтмол хурж байхад очиж суудаг л байсан. Одоо ч больж, Зүүн Чойр маань ламгүй болж байна. За нэг иймэрхүү.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон